



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**



германы
хамтын ажиллагаа

DEUTSCHE ZUSAMMENARBEIT

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ

20²⁰- он 12 сар 21-өдөр

Дугаар: 143/2020

Улаанбаатар хот

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА А.ЭНХБАТ ТАНАА**

Төслийн үйл ажиллагааны тайлан

хүргүүлэх тухай

Тус яамны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5 дугаар хавсралтын дагуу хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу

Хавсралт хуудастай

Хүндэтгэсэн,

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧАД АДАМСОН ТО
CLIMATE CHANGE
PROJECT
2012-65-511
Г.ЭРДЭНЭБАЯСГАЛАН

ТАНИЛЦСАН:
ТӨСЛИЙН УДИРДАХ
ХОРООНЫ ДАРГА ГАНБОЛД/

Засгийн газрын 2017 оны 89 р тогтоолын хавсралт Бодлогын
баримт бүчгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл
ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын
5 дугаар хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ГАДААДЫН БУЦАЛТГҮЙ
ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БҮЙ ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**
(2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар)

№	Төслийн агуулга	Гүйцэтгэл		
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	<p>“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөл Шийдвэр: 2013.11.13-ны Монгол Улсын Засгийн газар-ХБНГУ Засгийн газар хоорондын байгуулсан буцалтгүй тусlamжийн хэлэлцээр болон Төслийг сунгах тухай 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн шийдвэр Төслийн дугаар: BMZ 2012 65 511, BMZ 2016 67 054, BMZ 2018 68 272 Төслийн зорилго: Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг (орчны бүс болон экологийн коридори) бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино.</p>		
2	Санхүүжил-тийн эх үүсвэр	<p>ХБНГУ-ын Засгийн газар - Буцалтгүй тусlamж Монгол Улсын Засгийн газар</p>		
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БОАЖЯ, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх баг Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам, ТХБНУГН-ийн хамгаалалтын захиргаад Хэрэгжих хугацаа: 6 жил: 2015.05.01 - 2021.12.31 /1-р үе шат/ Хэрэгжих хугацаа: 7 жил: 2020.03.02 - 2027 /2,3-р үе шат/</p>		
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1: Тусгай хамгаалалттай газар нутгууд /ТХГН/ болон тэдгээрийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг сайжруулах, төслийн бэлтгэл хангах, Зорилт 2: ТХГН-ийн батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Зорилт 3: Үндэсний болон бүсийн түвшинд ТХГН-ийн сүлжээг бэхжүүлэх, Зорилт 4: Сургалт, бодлого, судалгааны хамтын ажиллагаа</p>		
5	Зардал	Төсөв(Нийт зардал)	<p>Төслийн 1-р үе шатны нийт төсөв 15.3 сая евро. ХБНГУ-ын Засгийн газар 11.5 сая евро, Монгол Улсын Засгийн Газар 6.65 тэрбум төгрөг. Төслийн 2-р үе шатны нийт төсөв 32.8 сая евро. ХБНГУ-ын Засгийн газар 27.5 сая евро, Монгол Улсын Засгийн Газар 14.8 тэрбум төгрөг</p>	
	Үүнд:	Төсөв (2020 он)	Гүйцэтгэл	Хувь

		ХБНГУ-ын Засгийн газар	11,500,000,000 төгрөг	2,293,008.08 евро	7,592,044,856.06 төгрөг	66 %
		МУ-ын Засгийн газар	616,938,800 төгрөг	123,540.01 евро	557,316,621.33 төгрөг	90 %
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Төслийн удирдах хорооны хурлаар Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан.				
	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Тусгай хамгаалалттай газар нутгууд болон тэдгээрийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг сайжруулах, төслийн бэлтгэл хангах	<p>1. Төслийн хүрээнд боловсруулсан менежментийн төлөвлөгөөг хэвлэх, төслийн дэвтэр, тор хэвлэх (ТХГН, аялал жуулчлал, Орчны бүс, ОНТХГН, г.м.,) /УАТ 1.01./:</p> <p>Төслийн хүрээнд 2016 онд Ноён хангай, Хорго, Тэрхийн цагаан нуур, Улаагчны хар нуур, Заг Байдрагийн голын сав газрын БЦГ, 2017 онд Горхи Тэрэлж, Орхоны хөндий, Монгол дагуур, Дорнод Монголын ДЦГ-ын ОБ-ийн МТ, Орхоны хөндийн БЦГ, Хорго-Тэрхийн Цагаан нуур, Отгонтэнгэр, Тарвагатай нурууны БЦГ-ын аялал жуулчлалын МТ, Хүйсийн найман нуурын БДГ-ын МТ, 2018 онд Отгонтэнгэр, Тарвагатайн нуруу, Хангайн нуруу, Орхоны хөндий, Зэд Хантай Бүтээлийн нуруу, Хөгнө Тарны, Хан Хэнтий, Онон Балж, Дорнод Монгол ДЦГ-ын МТ, 2019 онд Хан Хэнтий, Горхи Тэрэлжийн БЦГ-ын аялал жуулчлалын МТ буюу нийт 24 ТХГН-ийн төлөвлөгөөг боловсруулж, БОАЖЯ-ны ТХНУГ-т тайлагнаж, батлуулан, холбогдох Х3-дад хүлээлгэн өгсөнтэй холбогдуулан менежментийн төлөвлөгөө хэвлэх ажлын даалгаврыг боловсруулсны дагуу гэрээ байгуулан ажиллаж, төслийн лого бүхий сурталчилгааны 500 ширхэг тор, 300 ширхэг флаш, 1000 ширхэг балыг хийлгээд байна. Ажлын гүйцэтгэл 50%</p>				
	2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	<p>1. Дэд төслийн хүрээнд Х3-дыг хогны машин, завь, UTV болон цасны мотоцикл зэрэг тээврийн хэрэгслээр хангах ажлын хүрээнд /УАТ 2.01./:</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/131 дугаарт тушаалаар тус тендерийн үнэлгээний хороог шинэчлэн байгуулсны дагуу тендерийн үнэлгээг дахин хийж, сонгон шалгаруулалтыг явуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын тушаалын дагуу тендерийн ялагч "Протек" ХХК-тай MON/ICB014/2019 дугаартай ажлын гэрээг 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу УТХГ-ын Зэд хантай бүтээлийн нурууны ДЦГ, Отгонтэнгэр УТХГ, Хангайн нурууны БЦГ, Горхи Тэрэлжийн БЦГ, Дорнод Монгол УТХГ, Онон Балжийн БЦГ, Хан Хэнтийн УТХГ, Богд Хан уулын ДЦГ зэрэг нийт 8 Х3-нд UTV, цасны мотоцикл, завь, хогны машин зэрэг 4 төрлийн 23 ширхэг тээврийн хэрэгсэл /цар тахлын нөхцөл байдлын улмаас 5 UTV хоцорч байгаа/, хогны машины чингэлэг, хамгаалалтын дуулга, бээлий, нүдний шил, аврах хантааз зэрэг нийт 95 ширхэг дагалдах хэрэгслийн хамт нийлүүлэхэд бэлэн болсон ч Ковид-19 цар тахлын улмаас УОК-оос гарсан хорио дэглэмээс шалтгаалан гардуулан өгөх ёслолын ажиллагааг УОК-оос зөвшөөрөл аван зохион байгуулахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 95%</p> <p>2. Дэд төслийн хүрээнд баригдсан Х3, СМТ, байгаль хамгаалагчийн байруудыг тавилга, тоног төхөөрөмжээр</p>				

	<p>хамгаалагчийн байруудыг тавилга, тоног төхөөрөмжөөр хангах</p> <p>3. ажлын хүрээнд /УАТ 2.02/:</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/498 дугаарт тушаалын дагуу тендерийн ялагч “Долоон болдог” ХХК-тай 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр MON/ICB017 дугаартай гэрээг байгуулсан. Гэрээний дагуу гүйцэтгэгч “Долоон болдог” ХХК нь 25 төрлийн нийт 1421 ширхэг тавилгыг 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр хүлээлгэн өгсөн. Тус тавилгыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн 11 хамгаалалтын захиргаадад 2020 оны 02 дугаар сард хүлээлгэн өглөө. Ажлын гүйцэтгэл 100%</p> <p>3. Дэд төслийн хүрээнд баригдсан ХЗ, СМТ, байгаль хамгаалагчийн байруудыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах гэрээ байгуулах ажлын хүрээнд /УАТ 2.03/:</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/214, 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/326 дугаартай тушаалаар тус тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдөр дахин зарлах зөвшөөрлийг донор байгууллага KfW банкнаас хүлээн авсан. Тендерийг 2020 оны 07 дугаар сарын 24-нд зарлаж, тендерийн нээлтийг 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр хийж, 10 дугаар сарын 13-ны өдөр тендерийн үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулж, 11 дүгээр сард тендерийн үнэлгээний тайланг KfW банканд хүргүүлээд байна. Үнэлгээний тайланд германы талаас зөвшөөрлийг авч, тус оны 12 сард багтаан гэрээг байгуулахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 90%.</p> <p>4. Дэд төсөлд хамрагдсан ТХГН-т нэвтрэх хаалга, отоглох хоноглох цэгийг байгуулах ажлын хүрээнд /УАТ 2.04/:</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/255 дугаарт тушаалын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу явуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/352 дугаарт тушаалын дагуу тендерийн ялагч “Баядах өргөө” ХХК-тай YTA-№09-2020 дугаартай гэрээг 2020 оны 09 дүгээр сарын 08-ний өдөр байгуулсан. Гэрээний дагуу гүйцэтгэг компани нийт 11 отоглох хоноглох цэг, 8 нэвтрэх хаалгыг Отгонтэнгэр, Хан Хэнтий, Дорнод Монголын УТХГ, Онон-Балж, Горхи-Тэрэлж, Хөгнө-Тарна, Хорго-Тэрхийн Цагаан нуур, Тарвагатайн нуруу, Орхона хөндийн БЦГ-уудад байгуулах бөгөөд 7 газарт нэвтрэх хаалга, 8 газарт отоглох хоноглох цэгийг ХЗ-дад хүлээлгэн өгсөн. Ажлын гүйцэтгэл 90%</p> <p>5. Дэд төслийн хүрээнд Хустайн БЦГ-т байгаль хамгаалагч, мэргэжилтэн судлаачдын барилгын ажлыг гүйцэтгэх ажлын хүрээнд /УАТ 2.05./:</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2019 оны 08 сарын 19-ны өдрийн А/376 дугаарт тушаалын дагуу тендерийн ялагч “Спешилграндгрупп” ХХК-тай MON/ICB015/2019 дугаарт гэрээг 2018 оны 08 сарын 22-ны өдөр байгуулан ажилласны . дагуу тус барилгад улсын комиссыг 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдөр ажиллуулан, үүрэг</p>
--	--

даалгаврын биелэлтийг хамтран шалгаж, байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. **Ажлын гүйцэтгэл 100%**

6. ТХГН-ийн Орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих үйл ажиллагааны хүрээнд /УАТ 2.06./:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/254 дугаарт тушаалын дагуу тус ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу явуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/386 дугаарт тушаалын дагуу тендерийн ялагч “Дугант бар” ХХК-тай УТА-№10-2020 дугаартай гэрээг 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу гүйцэтгэг компани Онон Балжийн БЦГ-ын ХЗ-нд хадлангийн техник, дагалдах хэрэгслийг худалдан авч, нийлүүлэх, Зэд Хантай Бүтээлийн Нурууны ДЦГ-ын ХЗ-нд төмс, хүнсний ногооны 40 тонны зоорь, дагалдах хэрэгслийн хамт, 120 м²-ийн нийлэг хальсан хүлэмж-3 ширхэг (тус бүр дуслын усалгааны системтэй), Хорго-Тэрхийн цагаан нуурын БЦГ-ын жуулчдад үйлчлэх шинэ цэг байгуулах ажлын зургийг батлуулан, ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл 40%**

7. “Орчны бүсийн сангийн үйл ажиллагааг дэмжих” ажлын хүрээнд /УАТ 2.07./:

Төслийн хүрээнд ОБ-ийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг ХБНГУ-ын KfW банкнаас Монгол Улсын аль банкийг сонгох шийдвэр ирсний дагуу зарлахаар ажиллаж байна. Орчны бүсийн сантай холбоотойгоор олон улсын болон дотоодын богино хугацаат зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулж, германы талд хүргүүлсэн ч Covid-19 цар тахлын улмаас чиглэл ирээгүй тул тус ажил зохион байгуулагдаагүй. **Ажлын гүйцэтгэл үнэлэгдэхгүй.**

8. “Бурхан халдун уулын ДЦГ-ын ОБ-д амьдардаг иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын загвар төсөл” хэрэгжүүлэх ажлын хүрээнд /УАТ 2.08./:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/250 дугаарт тушаалын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу явуулсан. Тендерийн ялагч “Төгс үлэмжийн чанар” ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр хүргүүлсэн хэдий чтус компани тендерийн баталгаат хугацаа дуусахаас өмнө ажлын зургийг батлуулаагүй тул гэрээ байгуулах боломжгүй болоод байна. Тендерийг дахин зарлах ажлыг зохион байгуулж байна. **Ажлын гүйцэтгэл 25%**

9. Дэд төслийн хүрээнд Хустайн БЦГ-т генератор нийлүүлэх ажлын хүрээнд /УАТ 2.09./:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/132 дугаарт тушаалын дагуу “Хустайн БЦГ-ын ХЗ-нд 3 фазын нөөцийн цахилгаан үүсгүүр болон автомат сэлгэн залгагч нийлүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог

<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх</p>	<p>байгуулсны дагуу тендерийг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу явуулсан. Тендерийн үнэлгээний тайланг германы KFW банканд хүргүүлж, хариу шийдвэрийг хүлээж байна. Ажлын гүйцэтгэл 50%</p> <p>10. Дэд төслийн хүрээнд ХЗ-дыг УАЗ, трактор, соруулдаг машин, зөөврийн чингэлэг зэрэг бусад тээврийн хэрэгслээр хангах гэрээ байгуулах ажлын хүрээнд /УАТ 2.10/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/345 дугаартай тушаалаар тус тендерийн үнэлгээний хороог шинэчлэн байгуулсны дагуу тендерийг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу явуулсан. Тендерийн үнэлгээний хорооны хурлыг 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр хийж, үнэлгээний тайланг германы KFW банканд хүргүүлж, хариу шийдвэрийн дагуу 12 сард багтаан гэрээг байгуулна. Ажлын гүйцэтгэл 90%</p> <p>11. Дэд төслийн хүрээнд баригдсан ХЗ болон СМТ-ийн байрны АЦБ-ийн ажилд зөвлөхийн дэмжлэгтэйгээр хяналт тавих ажлын хүрээнд /УАТ 2.11/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2019 оны 10 сарын 28-ны өдрийн А/500 дугаарт тушаалын дагуу тендерийн ялагч “ЭнЭйПи Групп” ХХК-тай Хан Хэntий, Улаантайга, Отгонтэнгэрийн УТХГ, Онон Балж, Тарвагатай нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны байр, Сургалт мэдээллийн төвийн 6 барилгын АЦБ-ийн зураг төсөв боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих зөвлөх үлчилгээ үзүүлэх УТ08-2019 гэрээг 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу 6 барилгын ариун цэврийн байгууламжийн шийдлийн судалгаа бүхий ажлын тайлангийн зураг төслийг Барилгын хөгжлийн төвөөр батлуулж, 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хүлээн авсан. Тус ажлыг гүйцэтгэснээр хамгаалалтын захиргаа болон сургалт мэдээллийн төвийн байранд боловсон ОО барих ажлын даалгавар, техникийн үзүүлэлт, зураг төслийн дагуу гүйцэтгэх гэрээлэгч нарын ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах юм. Одоогийн байдлаар гэрээлэгч 5 компаний ариун цэврийн байгууламж, байгаль хамгаалагчийн байрны эко жорлонгийн ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж тайлан, зөвлөгөөг хүргүүлсэн. Ажлын гүйцэтгэл 100%</p> <p>12. Дэд төслийн хүрээнд баригдсан хамгаалалтын захиргаа болон сургалт мэдээллийн төвийн барилгад АЦБ барих ажлын хүрээнд /УАТ 2.12/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/256 дугаарт тушаалын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу явуулсан. Нийт багц ажлын гүйцэтгэл 62,5% Багц 1. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 08 сарын 19-ний А/330 дугаартай тушаалын дагуу тендерийн ялагч “Агар эрдэнэс” трейд ХХК-тай “Улаантайгын УТХГ- Хөвсгөл аймгийн Улаан уул сум дахь сургалт мэдээллийн төвийн барилгын өргөлт, ариун цэврийн байгууламж барих” УТА№07-04/2020 дугаартай гэрээг 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан. Гэрээний дагуу ажлын гүйцэтгэл 40% Багц- 2. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 08 сарын 19-ний А/331</p>
--	--

	<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх</p>	<p>дугаартай тушаалын дагуу тендерийн ялагч "Ангараг Од" ХХК-тай "Хэнтий аймгийн Дадал суманд баригдсан СМТ-ийн барилгад ариун цэврийн байгууламж барих, байгаль хамгаалагчийн 10 байранд эко жорлон барих" YTAN№08-01/2020 дугаартай гэрээг 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан. Гэрээний дагуу ажлын гүйцэтгэл 80% Багц 3. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/332 дугаартай тушаалын дагуу тендерийн ялагч "Нью Урбанизм" ХХК-тай "Хангайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны сургалт мэдээллийн төвийн байрны АЦБ барих" YTAN№07-01/2020 дугаартай гэрээг 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан. Гэрээний дагуу ажлын гүйцэтгэл 90% Багц 4. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/401 дугаартай тушаалын дагуу тендерийн ялагч "Нью Урбанизм" ХХК-тай "Хан Хэнтий болон Отгонтэнгэрийн УТХГ-ын хамгаалалтын захиргааны сургалт мэдээллийн төвийн байрны АЦБ барих" YTAN№07-02/2020 дугаартай гэрээг 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу ажлын гүйцэтгэл 40%</p> <p>13. Дэд төслийн хүрээнд баригдсан байгаль хамгаалагчийн байранд Эко 00 барих ажлын хүрээнд /УАТ 2.13/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/256 дугаарт тушаалын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг ТБОНХБАУХАТ хуулийн дагуу явуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/329 дугаартай тушаалын дагуу тендерийн ялагч "Дуулгат мөрөн" ХХК-тай "Дэд төсөлд багтсан ТХГН-ийн ХЗ-ны байгаль хамгаалагчийн байрны АЦБ-ийг барих" YTAN№08-02/2020 дугаартай гэрээг 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан. Гэрээний дагуу ажлын гүйцэтгэл 90%.</p> <p>14. "Орчны бүсийн сумдын Эргэлтийн сангийн зээлийн санхүүжилтийн үйл ажиллагааг эхлүүлэх" ажлын хүрээнд /УАТ 2.14./: Төслийн хүрээнд боловсруулсан Орчны бүсийн сангийн журам, удирдамж, гэрээний загвар, бусад дагалдах бичиг баримтуудын дагуу "Төрийн банк"-аар дамжуулан зээл олгох шийдвэрийг Сангийн яамнаас хүлээн авч, донор байгууллагад хүргүүлсэн. KfW банкны зүгээс Төрийн банканд магадлан шинжилгээг "BFC" ХХК-ний банкны санхүүгийн шинжээч хариуцан хийж байгааг мэдэгдсэн бөгөөд хариу зөвшөөрлийг хүлээж байна. Орчны бүсийн сантай холбоотойгоор олон улсын болон дотоодын богино хугацаат зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулж, германы талд хүргүүлсний дагуу KfW банкны зүгээс олон улсын зөвлөх ажиллуулах саналыг төслийн захиралд танилцуулж, зөвшөөрлийг аваад байна. Ажлын гүйцэтгэл 90%</p> <p>15. "Орчны бүсийн сумдад эмнэлгийн түргэн тусlamжийн машин нийлүүлэх" ажлын хүрээнд /УАТ 2.15./: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/88 дугаартай тушаалын дагуу тендерийн ялагч "Хурд Авто" ХХК-тай</p>
--	--	---

2020 оны 03 дугаар сарын 10-ны өдөр ажлын гэрээг байгуулсны дагуу гэрээний тургэн тусламжийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон нийт 16 автомашиныг дагалдах тоног төхөөрөмжийн хамт Дорнод Монгол, Улаан Тайга, Хан Хэntий, Отгонтэнгэр, Зэд Хантай Бүтээлийн нуруу, Онон Балж, Горхи Тэрэлж, Орхоны хөндий, Тарвагатайн нуруу, Хангайн нуруу, Хустайн нуруу зэрэг тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийнсумын эрүүл мэндийн төвүүдэд 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдөр хүлээлгэн өгсөн. Ажлын гүйцэтгэл 100%

16. “Дэд төслийн хүрээнд ТХГН-ийн ОБ-ийн сумдын сургуулийн эко кабинетыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах” ажлын хүрээнд /УАТ 2.16./:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/115 дугаарт тушаалын дагуу “Орчны бүсийн сумдын сургуулийн эко кабинетыг бий болгон тохижуулах” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу “Дэд төслийн хүрээнд ТХГН-ийн ОБ-ийн сумдын сургуулийн эко кабинетыг тавилга, тоног төхөөрөмжөөр хангах” ажлын хүрээнд /УАТ 2.17./ ажилтай нэгтгэн хоёр багц бүхий тендерийг ТБОНХБАУХАТ хуулийн дагуу явуулсан. Тендерийн үнэлгээний тайланг KW банканд хүргүүлж, 12 сард баатаан гэрээ байгуулахаар ажиллаж байна Ажлын гүйцэтгэл 60%.

17. “Дэд төслийн хүрээнд ТХГН-ийн ОБ-ийн сумдын сургуулийн эко кабинетыг тавилга, тоног төхөөрөмжөөр хангах” ажлын хүрээнд /УАТ 2.17./:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/115 дугаарт тушаалын дагуу “Орчны бүсийн сумдын сургуулийн эко кабинетыг бий болгон тохижуулах” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу “Дэд төслийн хүрээнд ТХГН-ийн ОБ-ийн сумдын сургуулийн эко кабинетыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах” /УАТ 2.16/-ын ажилтай нэгтгэн хоёр багц бүхий тендерийг ТБОНХБАУХАТ хуулийн дагуу явуулсан. Ажлын гүйцэтгэл 60%.

18. “Эко кабинетыг сургалт, судалгааны багаж, хэрэгслээр хангаж, багш нарыг чадавхжуулах” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /УАТ 2.18./:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/251 дугаарт тушаалын дагуу зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг ТБОНХБАУХАТ хуулийн дагуу явуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн А/360 дугаарт “Байгаль орчны сургалт мэдээллийн төв” ТББ-тэй 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр ЗСШ-05/2020 дугаартай гэрээг байгуулсан. Гэрээний дагуу Отгонтэнгэр УТХГ, Зэд ханай бүтээлийн нуруу БЦГ, Тарвагатайн нуруу БЦГ, Хангайн нуруу БЦГ, Орхоны хөндий БЦГ, Онон Балж БЦГ, Улаан тайга УТХГ, Горхи тэрэлж БЦГ, Хустайн нуруу БЦГ, Дорнод Монгол, Хан-Хэntийн УТХГН-ийн орчны бүсийн нийт 11 УТХГ-ын 48 сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдад мөн хамгаалалтын захиргааны мэргэжилтнүүдийг

		чадавхжуулах хөтөлбөрийг БОАЖЯ-аар хянуулан, чиглэл аван ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 80 %
3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Үндэсний болон бүсийн түвшинд Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх		<p>1. Биологийн олон янз байдлыг хамгаалах зөвлөл болон бусад сэдэвчилсэн ажлын хэсгийн хурлуудыг зохион байгуулах /YAT 3.01/:</p> <p>2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр төслийн хүрээнд хэрэгжиж буй загвар төслүүдийн ажлын тайлангийн хурлыг зохион байгуулж, БОЯБ-ын холбоос, ой, аялал жуулчлалын тогтвортой менежментийн загвар төслүүдийн явц, үр дүнг хэлэлцэж, цаашид эдгээр судалгаа, загвар төслүүдийн тогтвортой байдлыг хангах асуудлыг хэлэлцүүлсэн. Ажлын гүйцэтгэл 100 %</p> <p>2. Орхоны хөндийн БЦГ-т аялал жуулчлалын тогтвортой менежментийн загвар төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд /YAT 3.02/:</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2019 оны 08 сарын 09-ний өдрийн А/360 дугаарт тушаалын дагуу тендерийн ялагч "Компас саплай" ХХК-тай байгуулсан YT-03/2019 дугаартай гэрээний дагуу загвар төслийн хүрээнд хийгдсэн отглох цэг, тэмдэг тэмдэгжүүлэлт, Эко 00, мэдээллийн цэгийн байр зэрэг бүтээн байгуулалтын ажлын тайланг, холбогдох бичиг баримтын хамт 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр загвар төслийн тайлангийн хурлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнүүлэн хүлээн авсан. Ажлын гүйцэтгэл 100%</p> <p>3. Хангайн нурууны БЦГ-т бэлчээрийн тогтвортой менежментийн загвар төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд /YAT 3.03/ :</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2018 оны 11 сарын 07-ны өдрийн "Гэрээ байгуулах эрх олгох тухай" А/556 дугаарт тушаалын дагуу тендерийн ялагч "Бодлого судлалын төв" ТББ-тай байгуулсан 05/2018 дугаартай гэрээний дагуу тус ажлын үр дүнг ТХНУГ-т 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр танилцуулсны дагуу ажлын тайланг хүлээн авсан. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>4. Хангайн нурууны БЦГ-т Ойн тогтвортой менежментийн загвар төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд /YAT 3.04/:</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2019 оны 07 сарын 09-ний өдрийн А/324 дугаартай тушаалын дагуу тендерийн ялагч "Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл" ТББ-тай байгуулсан "Хангайн нурууны БЦГ-т ойн тогтвортой менежментийн загвар төсөл хэрэгжүүлэх" YT04-2019 дугаартай Тендерт хамгийн сайн үнэлгээ авч шалгарсан "Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл" ТББ-тай 2020 оны 07 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу загвар төслийн хүрээнд хийгдсэн мод үргүүлгийн газар, хүлэмжийн бүтээн байгууллалтын ажлын тайланг, холбогдох бичиг баримтын хамт 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр загвар төслийн тайлангийн хурлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнүүлэн хүлээн авсан. Ажлын гүйцэтгэл 100%</p> <p>5. Биологийн олон янз байдлын холбоос нутаг, эко коридорын загвар төслийг хэрэгжүүлэх /судалгаа, чадавх бэхжүүлэх, хамтын менежмент, худалдан авалт/ ажлын</p>

	<p>хүрээнд /УАТ 3.05/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2019 оны 12 сарын 26-ны өдрийн А/628 дугаарт тушаалын дагуу тендерийн ялагч "Коконэт" ТББ-тай байгуулсан YT-06/2019 дугаартай гэрээний дагуу загвар төслийн ажлын явцын тайланг, холбогдох бичиг баримтын хамт 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр загвар төслийн тайлангийн хурлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнүүлсэн. Ажлын гүйцэтгэл 80%</p> <p>6. Богдхаан уулын ДЦГ-ын газар зүй, кадастрын зураглал хийх ажлын хүрээнд /УАТ 3.06/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/186 дугаарт тушаалын дагуу "Богдхаан уулын ДЦГ-ын газрын кадастрыг улсын мэдээллийн санд холбох" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан. Санхүүжүүлэгч талын зүгээс зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах нэг тендерийн бүх явцыг хянан шалгаж "Post No objection" егсний дараа зөвлөхийн бусад тендерүүдийг нийтэд зарлах эрх олгох болсон тухай шийдвэрийг KfW-aас 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдөр ирүүлсэн. Тус шийдвэрийн дагуу "Богд хаан ДЦГ-ын кадастрыг улсын мэдээллийн санд холбох" №YT-02/2020 тендерийн процесс түр зогссон байна. Ажлын гүйцэтгэл 10%</p>
4-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Сургалт, бодлого, судалгааны хамтын ажиллагаа	<p>1. Холбогдох яамд болон ХЗ-аас зохион байгуулсан хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, нээлттэй хаалганы өдөрлөг, байгаль хамгаалах өдөр зэргийг дэмжих ажлын хүрээнд /УАТ 4.01/:</p> <p>1.1. УТХГН-уудын хамгаалалтын захиргаадын байгаль хамгаалагч, мэргэжилтэн нарт хамгаалалттай газар нутаг дахь хог хаягдлын менежментийг сайжруулах, биологийн төрөл зүйлийн бүртгэл судалгааны ажлыг менежменттэй зохион байгуулах аргачлал, байгаль орчны зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах аргачлал, тусгай хамгаалалттай газар нутгуудын нэмэлт төсөв, түүний зарцуулалт болон менежментийн үр ашигт байдлыг нэмэгдүүлэх, чиглэлээр нэгдсэн сургалтыг Зүүн бүсийн хамгаалалттай газар нутгуудын хамгаалалтын 5 захиргаадыг хамруулан 40 гаруй мэргэжилтэнг оролцуулан Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод 2020 оны 10 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд зохион байгуулсан.</p> <p>1.2. Төслийн бодлого үйл ажиллагааг танилцуулах хурлыг БОАЖЯ, KfW-ны Монгол дах төлөөлөгчийн газар болон төслийн зөвлөх багтай хамтран 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Байгаль хамгаалах, Цэнгэг ус төвд зохион байгуулсан ба хэрэгжүүлэгч талуудад төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой засгийн газар хоорондын гэрээ, үйл ажиллагааны хэрэгжилт, тулгамдаж буй асуудлуудын талаар танилцуулж хамтын шийдэлд хүрсэн.</p> <p>1.3. Дэд төсөлд хамрагдсан ТХГН-ийн орчны бүсийн сумдын эрүүл мэндийн төвд түргэн тусlamжийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон 16 автомашин гардуулан өгөх Ёслолын арга хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Төв цэнгэлдэхийн зогсоол дээр сайдын хэмжээнд зохион байгуулсан. Дээрх ажлуудын гүйцэтгэл 100%</p> <p>2. Хангайн бүсийн Сургалт, мэдээллийн төвийг тавилга, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /УАТ 4.02/:</p>

Тус ажлыг “Дэд төслийн хүрээнд баригдсан барилгуудыг тавилга, тоног төхөөрөмжөөр хангах” /YAT 2.02/ ажилтай нэгтгэн зохион байгуулж, ТХГН-ийн Хангайн нурууны ХЗ-нд 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр нийт 264 ширхэг тавилгыг хүлээлгэн өгсөн.
Ажлын гүйцэтгэл 100%

3. Хангайн бүсийн Сургалт, мэдээллийн төвийг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /YAT 4.03/:

Тус ажлыг “Дэд төслийн хүрээнд баригдсан барилгуудыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах” /YAT 2.03/-ын ажилтай нэгтгэн багцалж, тендерийг зохион байгуулахаар БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/214, 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/326 дугаартай тушаалаар тус тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдөр дахин зарлах зөвшөөрлийг донор байгууллага KfW банкнаас хүлээн авсан. Тендерийг 2020 оны 07 дугаар сарын 24-нд зарлаж, тендерийн нээлтийг 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр хийж, 10 дугаар сарын 13-ны өдөр тендерийн үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулж, 11 дүгээр сард тендерийн үнэлгээний тайланг KfW банканд хүргүүлээд байна. Үнэлгээний тайланд германы талаас зөвшөөрлийг авч, тус оны 12 сард багтаан гэрээг байгуулахаар ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл 90%.**

4. Төслийн сурталчилгааны материал, гарын авлага, брошур, богино хэмжээний видео, шторк хийх, төслийн цахим хуудас хөгжүүлэх ажлын хүрээнд /YAT 4.04/:

Төслийн I шат дуусахтай холбогдуулан хаалтын ажиллагаанд зориулж, төслийн үйл ажиллагааны үр дүнг нийтэд мэдээлэх, сурталчлах зорилгоор тус ажлыг 2020 оны IV улиралд төлөвлөсөн ба зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичигт KfW банкнаас “Үл татгалзах тухай мэдэгдэл”-ийг албан ёсоор авах хүртэл тус зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох тендерийн баримт бичгийг батлуулах, нийтэд зарлах ажил нь хойшлогдсон болно. Төслийн үндсэн мэдээллийн цахим хуудас Basscr.mn сайтын засвар, нэмэлт сайжруулалт, системийн алдагдлыг засварлах ажлын даалгаврыг боловсруулж, харьцуулалтын аргаар үнийн санал авч хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Юу Эйн Жи Би Сольюшн” ХХК-тай гэрээ байгуулахаар гэрээний төслийг БОАЖЯ-нд хүргүүлсэн. Тус ажлын дагуу төслийн веб сайтад нэмэлтээр оруулах мэдээлэл, контентыг бэлтгэсэн. **Ажлын гүйцэтгэл 30%**

5. ТХГН-т биологийн олон янз байдлын судалгаа хийх ажлын хүрээнд /YAT 4.05/:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2018 оны 11 сарын 07-ны өдрийн “Гэрээ байгуулах эрх олгох тухай” А/556 дугаарт тушаалын дагуу тендерийн ялагч “Шинжлэх ухааны академи ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн”-тэй байгуулсан 06/2018 дугаартай гэрээний дагуу Хустай, Горхи Тэрэлж, Хан Хэнтий, Зэд хантай бүтээлийн нуруу, Отгонтэнгэр, Тарвагатай, Улаан тайгын УТХГ-уудад БОЯБ-ын судалгааны ажлын үр дүнг БОАЖЯ-ны ТХНУГ-т 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр танилцуулсны дагуу ажлын

4-р зорилтын хүрээнд:
Хүрэх үр дүн:
Сургалт,
бодлого,

судалгааны хамтын ажиллагаа	<p>тайланг хүлээн авсан. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>6. Аялал жуулчлалын МТ боловсруулах /Горхи тэрэлж, Хан хэntий/ ажлын хүрээнд /YAT 4.06/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2019 оны 10 сарын 15-ны өдрийн А/477 дугаарт тушаалын дагуу тендерийн ялагч “Байгаль хамгаалах сургач, багш нарын сүлжээ” ТББ-тай байгуулсан YT-07/2019 дугаарт гэрээний дагуу Хан-хэntийн УТХГ, Горхи-Тэрэлжийн БЦГ-ын аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын үр дүнг БОАЖЯ-ны ТХНУГ-т 2020 оны 05 дугаар сард танилцуулсны дагуу ажлын тайланг хүлээн авсан. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>7. "ТХГН-ийн Хангайн бүсийн төвийн СМТ-ийн үзмэрийн танхим тохижуулах" ажлын хүрээнд /YAT 4.07/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/257 дугаарт тушаалын дагуу “ТХГН-ийн Хангайн бүсийн төвийн СМТ-ийн үзмэрийн танхим тохижуулах” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж, тендерийг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу явуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2019 оны 10 сарын 15-ны өдрийн А/477 дугаарт тушаалын дагуу тендерийн ялагч “Ворк мастер” ХХК-тай 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр YTANо 06/2020 дугаартай гэрээг байгуулсан. Гэрээний дагуу гүйцэтгэгч тал Хангайн бүсийн үзмэрийн танхим тохижуулах, бүсийн 7 хамгаалалтын захиргааны мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн электрон самбар хийх ажлын зураг төслийг захиалагч талаар батлуулсны дагуу тохижилт, 3D макет хийх, мэдээллийн сан боловсруулах зэрэг ажлуудыг гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 80%</p> <p>8. ТХГН-ийн бодлого төлөвлөлт, стандарт, аргазүйг сайжруулах, БО-ны хуулиудын давхардал, хийдлийг судлахад БОАЖЯ-нд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд /YAT 4.08/: БОАЖЯ-ны үйл ажиллагааны хүрээнд салбарын стандарт, норм нормативыг сайжруулах, хуулиудын давхардал, хийдлийг судлах зорилгоор тус ажлыг төлөвлөж, БОАЖЯ-аас чиглэл ирээгүй тул тус ажил зохион байгуулагдаагүй. Ажлын гүйцэтгэл үнэлэгдэхгүй.</p> <p>9. ТХГН-ийн менежмент, ХЗ-ны бүтэц үйл ажиллагаа, байгаль хамгаалагчдад шаардлагатай техник хэрэгслийг судалж үнэлгээ хийж зөвлөмж боловсруулах ажлын хүрээнд /YAT 4.09/: БОАЖЯ-ны үйл ажиллагааны хүрээнд УТХГ-т хэрэгжүүлэх бусад саналыг хэрэгжүүлэх боломжийг судлах зорилгоор тус ажлыг төлөвлөж, БОАЖЯ-аас чиглэл ирээгүй тул тус ажил зохион байгуулагдаагүй. Ажлын гүйцэтгэл үнэлэгдэхгүй.</p>
	<p>Төслийн үйл ажиллагаа, ХАА ажиллагааны төлөвлөгөөнүүдийг батлуулж, тайланг хүргүүлэх ажлын хүрээнд /PM01/: Төслийн Удирдах хорооны 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хурлаар Төслийн үйл ажиллагааны болон худалдан авалтын төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан. Ажлын гүйцэтгэл 100%.</p>

	<p>“Төслийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудит, санхүүгийн хянан баталгаажуулалтыг хийх” ажлын хүрээнд /PM02/:</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/86 дугаарт тушаалын дагуу “Интер аудит” ХХК-тай УАГ/АА 2020-45/02/2020 дугаарт гэрээг 2020 оны 02 дугаар сарын 20-ний өдөр байгуулсан. Гэрээний дагуу эцсийн тайланг 03 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авсан. Аудитын зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 06 сард хүргүүлсэн. Ажлын гүйцэтгэл 100%.</p>
	<p>“Төслийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудит, санхүүгийн хянан баталгаажуулалтыг хийх” ажлын хүрээнд /PM03/:</p> <p>Төслийн 2020 оны үйл ажиллагаанд аудит хийх ажлын гэрээг тус оны IV улиралд багтаан байгуулахаар төлөвлөсөн. Тус ажил нь Үндэсний Аудитын Газраас нэгдсэн журмаар бүх төслүүдийг хамруулан 12 дугаар сард гүйцэтгэгч аудитын компанийг сонгон шалгаруулж томилдог болно. УАГ-аас чиглэл ирээгүй тул тус ажил зохион байгуулагдаагүй. Ажлын гүйцэтгэл үнэлэгдэхгүй.</p>
	<p>Төслийн удирдах хорооны ажлын хүрээнд /PM04/:</p> <p>Төслийн УХ-ны хурлыг 2020 оны 03 дугаар сарын 18-ны, 05 дугаар сарын 21-ний өдөр БОАЖЯ-ны Хaan танхимд, 12 дугаар дүгээр сарын 9-ний өдөр цахимаар тус тус зохион байгуулж, төслийн I шатны 2015-2019 онд хийсэн ажлын тайлан, 2020 оны үйл ажиллагаа болон худалдан авалтын тайлан, 2021 оны төлөвлөгөө, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ ажлуудыг хэлэлцсэн. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>KfW-ийн үнэлгээний багийн ажлын хүрээнд/PM05/:</p> <p>Төслийн явцын үнэлгээний KfW банкны баг дэлхий нийтэд тархаад байгаа Covid-19 цар тахлын улмаас болон Монгол улсад ирээгүй тул тус ажил зохион байгуулагдаагүй. Ажлын гүйцэтгэл үнэлэгдэхгүй.</p> <p>Төслийн Хяналт үнэлгээ, мониторинг хийх ажлын хүрээнд /M01/:</p> <p>Төслийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалтын ашиглалт, чанар болон тогтвортой байдлыг шалгах зорилгоор төслийн үйл ажиллагааны хяналт үнэлгээний төлөвлөгөөг батлуулсан. Тус төлөвлөгөөний дагуу удирдамжуудыг боловсруулж, орон нутагт томилтоор ажилласан:</p> <ol style="list-style-type: none"> 1. 2020.05.27-ны өдөр Төв аймагт ажиллаж, Хустайн БЦГ-ын ХЗ-ны байгаль хамгаалагч, судлаач нарын ажиллаж амьдрах байрны барилгад хяналт тавин ажилласан. 2. 2020.07.22-25-ны өдрүүдэд Төв, Архангай, Өвөрхангай аймгуудад томилтоор ажиллаж, Хустайн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч, судлаач нарын ажиллаж амьдрах байрны нээлтийн ажиллагааны бэлтгэлийг хангах, Хангайн нурууны БЦГ-т хэрэгжиж буй Ойн тогтвортой менежментийн загвар төслийн хүрээнд баригдсан мод үржүүлгийн газрын үйл ажиллагаатай

	<p>танилцах, Орхоны хөндийн БЦГ-т хэрэгжиж буй Аялал жуулчлалын тогтвортой менежментийн загвар төслийн хүрээнд баригдсан отоглох цэгийн бүтээн байгуулалтын ажлын явцыг шалгасан.</p> <p>3. Төслийн хүрээнд баригдаж буй АЦБ-ийн ажлын хяналтаар 2020.08.22-29-ний өдрүүдэд Өвөрхангай, Архангай, Завхан аймгуудад, 2020.10.22-25-ны өдрүүдэд Хөвсгөл, Булган аймгуудад, 2020.10.27-30-ний өдрүүдэд Хэнтий аймагт тус тус томилолтоор ажиллаж, ТХГН –ийн ХЗ-дад баригдсан барилгын ажлын гүйцэтгэл, ашиглалт, гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн.</p> <p>4. Төслийн барилгын ажлын хяналттай холбогдуулан төслийн барилгын зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулж, сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангасан.</p> <p>5. Үр дүнд суурилсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлагын мэдээллийн нэгдсэн санд төслийн мэдээллийг тухай бүрт оруулж ажилласан. Дээрх ажлуудын гүйцэтгэл 100%</p> <p>Санхүүгийн ерөнхий тайлан: БОАЖЯ-ны СХ болон СЯ-нд төслийн I,II,III шатны 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөллийг хийж 2020 оны 05-дугаар сарын 06-ны өдрийн 34/2020 тоот, 2020 оны 07-дугаар сарын 28-ны өдрийн 08/5153 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. НӨАТ-ын тайланг цаасаар болон цахим хэлбэрээр сар бүр хийж Татварын ерөнхий газарт хүргүүлж байна. Шилэн дансны тайлан мэдээг сар бүр шинэчлэн хийж, БОАЖЯ-ны дотоод аудит хяналт үнэлгээний газарт улирал бүр нэгтгэн цахимаар илгээж байна. Төслийн тусгай болон дэд дансны санхүүгийн тайлан болон санхүүжилтийн төлөвлөгөөг 4 сар тутамд бэлтгэж ХБНГУ-ын KfW банканд хүргүүлж байна. Ажлын гүйцэтгэл 100%</p>
Төслийн II, III шатны үйл ажиллагааны гүйцэтгэл 50%-тай байна.	<p>1. Кластерийн менежментийн суурь үзүүлэлтийг тодорхойлох зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд сонгон шалгаруулалтын үнэлгээний хороог байгуулсны дагуу ажлын даалгавар, техникийн нөхцөлийн тодорхойлолтыг боловсруулсан. Санхүүжүүлэгч талын зүгээс тус тендерийн явцыг хянан шалгаж "Post No objection" өгсний дараа зөвлөхийн бусад тендерүүдийг нийтэд зарлах эрх олгох болсон тухай шийдвэрийг KfW-аас 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдөр ирүүлсэн. Зөвлөх үйлчилгээний тендерүүдийн эрхийг нээх шийдвэрийг KfW банкнаас хүлээж байна. Ажлын гүйцэтгэл 30%</p> <p>2. Ой, бэлчээрийн нөхцөл байдлын суурь үзүүлэлтийг тодорхойлох зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд сонгон шалгаруулалтын үнэлгээний хороог байгуулсан. Ажлын даалгаврыг боловсруулж, санхүүжүүлэгч талд хүргүүлсэн. Санхүүжүүлэгч талын зүгээс зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах нэг тендерийг хянан шалгасны дараа зөвлөх үйлчилгээний тендерүүдийн эрхийг нээх тул KfW банкнаас шийдвэрийг хүлээж байна.</p> <p>Ажлын гүйцэтгэл 30%</p>

	<p>3. Санхүүгийн зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд ажлын даалгаврыг боловсруулж, сонгон шалгаруулалтыг ТБОНХБАУХАТ хуулийн дагуу явуулсан. KfW-ын худалдан авалтын удирдамж, санхүүгийн журмыг МУ-ын хууль, дүрэм журамтай нийцүүлэх ажлын тайланг 2020 оны 12 сард багтаан хүлээн авахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 100%</p> <p>4. Кластерт хамрагдсан байгаль орчны байгууллагуудыг автомшинаар хангах ажлын хүрээнд сонгон шалгаруулалтын үнэлгээний хороог байгуулсан. Ажлын даалгавар, ТББ-ийг боловсруулж, санхүүжүүлэгч талд хүргүүлэн, хариу зөвшөөрлийг авахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 30%</p> <p>5. Байгаль хамгаалагчдыг өвөл, зуны дүрэмт хувцсаар хангах ажлын хүрээнд сонгон шалгаруулалтын үнэлгээний хороог байгуулсан. Ажлын даалгавар, техникийн нөхцөлийн тодорхойлолтын төслийг гаргасан, холбогдох газруудаас санал авахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 30%</p> <p>6. ТХН-ийг оффисын тавилга, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд сонгон шалгаруулалтын үнэлгээний хороог байгуулсан. Ажлын даалгавар, техникийн нөхцөлийн тодорхойлолтыг батлуулсны дагуу тендерийг зарлаж, нээлтийг 2020 оны 12 сарын 11-ний өдөр хийнэ. Тус ажлын гэрээг 12 сард багтаан байгуулахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 80%</p>
7	<p>Ололт, амжилт:</p> <p>Төслийн II, III шат эхлэхтэй холбогдуулан ХБНГУ-ын KfW банкнаас Зөвлөх багийг сонгон шалгаруулж, 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр БОАЖЯ-ны ТНБД болон “Эко консалтинг” ХХК хоорондын хамтын ажиллагааны гэрээг байгуулснаар төслийн II, III шат албан ёсоор эхэлсэн.</p> <p>Төслийн I үе шатыг Монголын талын нэмэлт санхүүжилтгүйгээр 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгаад байна.</p> <p>БОАЖ-ын болон Сангийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог батлах тухай” 115/A/405 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог батлуулсан.</p> <p>Төслийн тусгай, дэд дансанд 2015 оноос хойш хуримтлагдсан хүүгийн орлогыг төслийн үйл ажиллагаатай холбоотой зардалд зарцуулах зөвшөөрлийг KfW банкнаас 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр хүлээн аваад байна.</p> <p>Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 2020 оны 12 сарын сүүлийн байдлаар нийт 9 сая 632 мянга гаруй euro буюу нийт төсвийн 80%-ийн хөрөнгө оруулалтыг хийгээд байна..</p> <p>Цаашид анхаарах асуудлууд, дутагдал:</p> <p>COVID 19 цар тахал, хөл хорионы улмаас гэрээлэгчийн ажлыг хүлээн авах хугацааг хойшлуулж, гэрээг сунгаж ажилласантай холбогдуулан цаашид нөхцөл байдал дээрдэхгүй тохиолдолд давагдашгүй хүчин зүйлийг харгалзан, тендер болон гэрээний хугацааг тооцоолоход анхаарах,</p>

		XAA-ны үнэлгээний хороонд ажиллах АЗ сертификаттай мэргэжилтнүүд дутмаг, мөн түүнчлэн ажлын хэсэг, үнэлгээний хороонд холбогдох чиглэлээр мэргэжлийн хүнийг оруулж ажиллахад анхаарах, Төслөөс нийлүүлсэн техник тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг тооцож ХЗ-ын жил жилийн төсөвт баталж өгдөг байх, Засгийн газар хоорондын хэлэлцээрт заасан төсөлд оруулах Монголын талаас оруулах хөрөнгө оруулалт хангалтгүй байгааг анхаарч, монголын талын оролцоог сайжруулах зэрэг болно.				
8	Төслийг хэрэгжүүлэгч талуудын х/а-нд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Tөслийн 1-р үе шатны хугацааг хамарсан худалдан авах ажиллагаа болон 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд БОАЖЯ-аас дотоод аудитын хяналт шалгалт хийгдсэн. 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 30 дугаартай Дотоод аудитын хорооны тогтоолоор дотоод аудитын ажлын тайлангийн үр дүн гарсан. Тус тогтоолын биелэлтийг ханган ажиллаж илрүүлсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2020 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 83/2020 дугаартай албан бичгээр ХШУДАГТ-т хүргүүлж ажилласан.				
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ) Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж %	Менежмент Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4 Мониторинг
			3 ажил-100%, 2 ажил-50%	1 ажил- 95%, 5 ажил- 90%, 1 ажил- 80%, 2 ажил- 62,5%, 2 ажил- 60%, 1 ажил- 50%, 1 ажил- 40% 1 ажил-25% 1 ажил- үнэлэгдэхгүй	4 ажил- 100%, 1 ажил- 90%, 1 ажил- 80%, 1 ажил- 10%	4 ажил- 100%, 1 ажил- 90%, 1 ажил- 80%, 1 ажил- 30%, 2 ажил- үнэлэгдэхгүй
						<p>Нийт 2020 онд төлөвлөсөн ажил: 40 ажил. Үүнээс: 5 ажил үнэлэгдэхгүй Үндэсний аудитын газраас гүйцэтгэгчийг томилоогүй учир 2020 оны аудитын ажил/PM03/, Covid-19 цар тахлын улмаас KfW-ийн үнэлгээний баг ирээгүй/PM05/, германы талаас чиглэл ирээгүй тул ОБ-ийн зөвлөхийн ажил, БОАЖЯ-наас чиглэл ирээгүй тул ТХГН-ийн бодлого төлөвлөлт, стандарт, аргазүйг сайжруулах, ТХГН-ийн менежмент, ХЗ-ны бүтэц үйл ажиллагаа, байгаль хамгаалагчдад шаардлагатай техник хэрэгслийн үнэлгээ хийх зэрэг ажлууд ирэх оны төлөвлөгөөнд орж хойшлоод байна. Үнэлсэн: 34 ажил. Үүнээс: 100%-тай=16</p>

		95%-тай=1 90%-тай =6 80%-тай=3 62,5%-тай=1 60%-тай=2 50%-тай=2 40%-тай=1 30%-тай=1 25%-тай=1 10%-тай=1
		Гүйцэтгэлийн хувь: Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 2020 оны байдлаар 84.2% -тай байна.
1 0	ЗГХЭГ-ЫН ҮНЭЛГЭЭ	Нэгдсэн үнэлгээ ... %

Нэмэлт мэдээлэл /сая төгрөгөөр/							
11	Зарцуулалт	2015	2016	2017	2018	2019	2020
	ХБНГУ-ЫН Засгийн газар	452.81₮	1,763.54₮	5,415.49₮	5,864.21₮	4,728.84₮	7,592,₮
	МУ-ЫН Засгийн газар	482.16₮	465.98₮	544.07₮	492.15₮	383.50₮	557,32₮
12	Жендерийн мэдээлэл	Тус төсөл нь санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж байгаа төсөл бөгөөд 2020 онд явуулсан үйл ажиллагаанд жендерийн ажил хийгдээгүй боловч 2021 оноос байгаль орчин, нийгмийн асуудлаар мэргэжлийн боловсон хүчин холбогдох судалгаа, нөлөөллийн үнэлгээг хийх болно.					
13	Суурь судалгаа хийгдсэн эсэх	2015-2016 онуудад 11 УТХГ-ЫН орчны бүсийн сумуудад Бэлчээрийн тогтвортой менежментийн суурь мэдээлэл бүрдүүлэх судалгаа, ойн тогтвортой менежментийн суурь мэдээлэл бүрдүүлэх судалгаа, Биологийн олон янз байдлын суурь мэдээлэл бүрдүүлэх судалгаа хийх, нийгэм эдийн засгийн суурь мэдээлэл бүрдүүлэх судалгаа, Тогтвортой амьжиргааг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх <i>Мал аж ахуй эрхлэх, мал аж ахуйн гаралтай бүтгээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотой төслүүдэд бизнесийн болон чадавхын үнэлгээ хийх</i> " хийгдсэн.					

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТЕСӨЛ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН- 2020.12**

Төгрөгээр
Еврогоор

	Тайлант хугацаа 2020.12		Өссөн дүнгээр	
Орлого	евро	төгрөгээр	евро	төгрөгээр
KfW				
Шууд санхүүжилт (Зөвлөх)	694,781.54	2,286,569,196.11	1,970,466.58	5,629,699,211.35
Хялбаршуулсан шууд санхүүжилт	821,462.22	2,685,585,481.87	1,349,107.22	4,205,430,336.03
Татан төвлөрүүлэлтийн данс	350,000.00	1,109,591,000.00	5,694,086.38	15,986,025,724.69
KfW-орсон нийт санхүүжилт	1,866,243.76	6,081,745,677.98	9,013,660.18	25,821,155,272.07
Хүүгийн орлого	4,863.11	14,861,676.88	68,607.84	196,282,683.97
МУЗГ				
Төрийн сан	182,394.43	616,945,500.00	1,139,518.41	3,125,469,200.00
Нийт санхүүжилт/Орлого	2,053,501.30	6,713,552,854.86	10,221,786.43	29,142,907,156.05
Зардал				
KfW	2,276,292.23	7,531,416,513.56	8,949,954.94	25,985,454,067.71
МУЗГ	123,540.01	557,316,621.33	1,033,942.75	2,925,165,920.03
МУЗГ-т буцаан шилжүүлсэн	-	-	46,721.24	140,674,401.30
Гадаад ханшийн зерүү	-	(239,718,590.09)		(417,663,994.39)
Нийт зардал	2,399,832.24	7,849,014,544.80	10,030,618.93	28,633,630,394.65
Үр дүн	(346,330.94)	(1,135,461,689.94)	191,167.50	509,276,761.40
Урьдчилгаа	-	-	-	-
Цэвэр мөнгөн хөрөнгө	(346,330.94)	(1,135,461,689.94)	191,167.50	509,276,761.40
Эхний үлдэгдэл	-	-	-	-
KfW				
Тусгай данс	520,489.53	1,593,218,451.33	-	-
дэд данс	17,008.91	51,520,000.00	-	-
KfW-ийн нийлбэр	537,498.44	1,644,738,451.33	-	-
МУЗГ				
Төрийн сан	-	-	-	-
Эхний үлдэгдлийн нийлбэр	537,498.44	1,644,738,451.33	-	-
Эцсийн үлдэгдэл	191,167.50	509,276,761.39	191,167.50	509,276,761.40
KfW				
Тусгай данс	132,107.80	449,021,211.35	132,107.80	449,021,211.35
дэд данс	205.28	626,671.38	205.28	626,671.38
KfW-ийн эцсийн үлдэгдлийн нийлбэр	132,313.09	449,647,882.73	132,313.09	449,647,882.73
МУЗГ				
Төрийн сан	58,854.42	59,628,878.67	58,854.42	59,628,878.67
Эцсийн үлдэгдлийн нийлбэр	191,167.50	509,276,761.40	191,167.50	509,276,761.40


Тусгай дансны ханш орлого орж ирсэн өдрийн Монгол банкны албан ханшаар / аудитын зөвлөмжөөр
Дэд дансны ханш нь тусгай данснаас шилжүүлэг хийсэн өдрийн арилжааны банкны ханш / аудитын зөвлөмжөөр
МУГЗ-ын санхүүжилт орж ирсэн өдөр болгоны Монгол банкны албан ханшаар / аудитын зөвлөмжөөр

ТАНИЛЦСАН:

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ БҮС НУТГИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА,
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

ТӨСЛИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН АЖИЛТАН


Ч.БАТСАНСАР


Г.ЭРДЭНЭБАЯСГАЛАН


Г.САЙНБАЯР